



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№115 /559/

2023.07.26

Цаг үе, үйл явдал

ДАЛАЙ ЭЭЖИЙГ АВРАХ АЖИЛД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТОМИЛГООТ БҮРЭЛДЭХҮҮН МАНЛАЙЛАХ ҮҮРЭГТЭЙ ОРОЛЦОЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, хог хаягдлыг нь цэвэрлэх, бохирдлыг нь бууруулах зорилгоор ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Инженерийн дарга хурандаа Ц.Ганхөлөгөөр ахлуулсан Зэвсэгт хүчний 186, 234 дүгээр ангийн 30 цэргийн алба хаагч Хөвсгөл аймагт 6 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн 15 нэгж техниктэйгээр ажиллаж байгаа юм.

Энэхүү бүтээлч ажил нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслүүдийг илрүүлэх, байршлыг нь тогтоох, татан гаргах ажил бөгөөд уг ажлыг Зэвсэгт хүчний томилгоот бүрэлдэхүүн, Онцгой байдлын албаны аврагч нар, ШУТИС-ийн инженерийн багийн эрдэмтэд хамтран хэрэгжүүлж

байгаад иргэд ихээхэн талархаж буй.

Энэхүү ажлын хэсгийн бүрэлдэхүүн өнгөрсөн хугацаанд буюу 2021 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр уг нуурт 1985 онд живсэн "Сүхбаатар" хөлөг онгоцыг татан гаргасан нь олны талархлыг хүлээсэн.

Тэд энэ оноос үйл ажиллагаагаа эрчимжүүлэн 2023 оны 7 дугаар сарын нэгний өдөр уг нуурын гүнд 55 жил болсон тракторыг татан гаргасан.

Мөн энэ сарын 25-ны өдөр нуурын гүнд 28 жил болсон "ЗИЛ-130" автомашиныг татан гаргах ажлыг амжилттай гүйцэтгээд байгаа ба энэ нь уг ажлын

хэсгийн удирдлага, хамт олны гар нийлэмжтэй ажиллагааны үр дүн төдийгүй ихээхэн хүч хөдөлмөр, авхаалж самбаа шаардсан бүтээлч үйл ажиллагаа юм.

Энэхүү Хөвсгөл нуурт живсэн машин, техникийг гаргах ажилд Зэвсэгт хүчнээс мэргэжлийн удирдлагаар хангахаар ЗХЖШ-аас гурав, тээвэрлэх ажлыг гүйцэтгэхээр Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн 24, Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн 3 цэргийн алба хаагч идэвх зүтгэлтэй ажиллаж байгаад чин сэтгэлийн талархал илэрхийлэе.

Хурандаа
Б.ОТГОНБАЯР



БРИГАДЫН ГЕНЕРАЛ Ж.ӨСӨХБАЯР ЦАГ ҮЕИЙН АСУУДЛААР ҮҮРЭГ ЧИГЛЭЛ ӨГЛӨӨ



Энэ сард Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн улсын хэмжээнд явагдсан цөөнгүй арга хэмжээ болох нийслэлд үүссэн үерийн уршгийг арилгах, иргэдийн амь нас, эд хөрөнгийг авран хамгаалах ажилд дэмжлэг үзүүлсний зэрэгцээ Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх ажилд Зэвсэгт хүчнээс өргөн бүрэлдэхүүнээр оролцож тавигдсан үүргээ амжилттай биелүүлснийг уулзалтын эхэнд онцлоло.

Уулзалтад Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал Ж.Өсөхбаяр, ЗХЖШ-ын ахлагч тэргүүн ахлагч Н.Баасан, БИЦУГ-ын удирдлага, Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангийн захирагч нар танхимаар, Төрлийн цэргийн командлалын удирдлага болон хөдөө орон нутгийн захирагч нар цахимаар оролцлоо.

Цаашид хэрэгжүүлэх цаг үеийн ажил арга, хэмжээг тодотгож, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цэргийн алба, нууц хадгалалт, хамгаалалт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, харуул, хоногийн манаа болон томилгоот бүлгийн үүрэг гүйцэтгэлт, хугацаат цэргийн алба хаагчид болон оюутан цэргийн сургалт бэлтгэлд онцгой анхаарч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг нэгтгэл анги, байгууллагын захирагч, штабын дарга нарт үүрэг болголоо.

ГОВИЙН НӨХЦӨЛД АМЬД ГАРАХ АРГА УХААНД СУРАЛЦЛАА



Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн Сургалтын төвд явагдаж байгаа "Оюутан цэрэг-2023" сургалтад хамрагдаж буй бүрэлдэхүүний гар нийлэмжтэй ажиллагааг хангах, бие бялдар, тэсвэр хатуужил олгох, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг ахиулах зорилгоор энэ сарын 22-ны өдөр "Тактик, тусгай бэлтгэлийн цогцолбор" 20 километрийн явган маршийг амжилттай зохион байгууллаа.

Энэхүү 20 километрийн явган маршийн хичээлийн явцад хариуцлагын бүсийн газар орныг хэсэгчлэн судлах, зэвсэг, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэйгээр говь хээрийн газар орноор явган марш үйлдэж, жижиг бүлгийн байлдааны ажиллагаанд үүрэг гүйцэтгэх дадлага, ур чадварыг нэмэгдүүлж, төрөл бүрийн дасгал, нормативыг боловсруулж, говь хээрийн нөхцөлд гарын доорх материал ашиглан урц, оромж барих, гал гаргах зэрэг амьд гарах арга ухааны хичээлийг хослуулан явуулснаараа онцлогтой байлаа.

Ахлах дэслэгч Б.БАТЗАЯА



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 22	🌧️ 13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,429	3,437
EUR 🇪🇺	3,800	3,830
CNY 🇨🇳	480	487
RUB 🇷🇺	38.10	38.30
JPY 🇯🇵	24	25.10
KRW 🇰🇷	2.65	2.69

ЗУРХАЙ



2023.07.26 /ЛХАГВА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 8

**ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ
САР
ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ
ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:

Нас уртасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.21-20.37

Барилдлага:

Үл зохилдох

ШҮТЭН БАРИЛДАГА:

Тийн мэдэхүй

ухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 691,400,034

Эдгэрсэн

Нийт: 664,210,023

Нас барсан

Нийт: 6,903,990

Цахим шууданд

БОДИТ ЦАГИЙН БАЙДАЛД НИЙЦҮҮЛСЭН 5 ЦЭГТ ДААЛГАВАР ГҮЙЦЭТГҮҮЛЭЭ



саад, эр зориг, тэсвэр тэвчээрийг шалгасан хичээлүүдийг 5 цэгээр явуулж, богино хугацаанд оновчтой шийдвэр гаргах, айдсаа давах, бусдад туслах, багаар ажиллах чадваруудыг нь дээшлүүлээ.

Тодруулбал, амьд гарах арга ухаан, отолт, түр амралт буюу соёл хүмүүжлийн ажил, тактикийн ажиллагаа, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн цэгийг тус тус төхөөрөмжилж бэлтгэн даалгавар гүйцэтгүүлэв. Сэтгэл зүйн хичээлийн цэгт гэхэд айдсаа давах, бодит байдлыг тооцоолох чадвар суулгах үүднээс утаа, тэсэрч дэлбэрэх сургалтын макет, сургалтын сум, дайны талбарын дуу чимээг оруулж, орчин нөхцөлийг нь хүнд цагийн байдалд ойртуулсан нь түрүүч, байлдагч нарын нэг бүрийн бэлтгэлийг улам бататгаж чадсан юм.

Ахлах дэслэгч Б.БЭРХБААТАР



Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд явагдаж байгаа "Оюутан цэрэг-2023" сургалтынхан төлөвлөгөөний дагуу ээлжит 20 км явган маршийг 7 дугаар сарын 23-ны өдөр хоёр үе шаттайгаар зохион байгуулж явууллаа.

Явган маршийн үеэр оюутан цэргүүдийн сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэх, хатуужил олгох хүрээнд тусгай төлөвлөгөө боловсруулан ус болон галын

ҮНДЭСНИЙ ШАГАЙН ХАРВААГААР ТЭРГҮҮЛЭЭ



наадмын шагайн харвааны тэмцээнд багийн төрөлд тус тус тэргүүн байр, ахлах ахлагч Ж.Ганзоригт Баянхонгор аймгийн баяр наадмын Үндэсний шагайн харвааны тэмцээний хувийн цувааны төрөлд дэд байр эзэллээ. Мөн Эрдэнэцогт, Бууцагаан сумын баяр наадмын шагайн харвааны хувийн цувааны төрөлд тэргүүн байр тус тус эзэлсэн юм.

Дэслэгч Б.ПАГАМДУЛАМ




Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн Үндэсний шагайн харвааны "Соёмбо" баг ганзага дүүрэн наадлаа. Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ойн Баянхонгор аймаг, сумын баяр наадмын Үндэсний шагайн харвааны тэмцээнд Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн "Соёмбо" баг амжилттай оролцлоо. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Бууцагаан сумдын баяр

Гэрэл зураг түүх өгүүлнэ



"ТУНГАЛАГ МЭЛМИЙ-2023" САЙН ДУРЫН ХҮМҮҮНЛЭГИЙН АЖИЛЛАГАА ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН ХОТОД ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА



Монгол цэргийн нэгдсэн холбооноос БНСУ-ын Нүдний шилний нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж байгаа "Тунгалаг мэлмий-2023" сайн дурын хүмүүнлэгийн ажиллагаа Хөвсгөл аймагт явагдлаа.

Энэхүү хүмүүнлэгийн ажиллагаанд Хөвсгөл аймаг дахь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 150 гаруй ажилтан, алба хаагч, ахмадууд, тэдний гэр бүлийн гишүүдийг хамруулж, тэдний нүдний харааг үнэ төлбөргүй оношлуулж, авто рефрактоороор шалгаж, тухайн хүний нүдний хараанд тохирсон шилийг газар дээр нь тааруулан олгов. Тохирсон харааны шил байхгүй тохиолдолд БНСУ-д захиалан хийлгэх арга хэмжээ авч ажиллав.

Хүмүүнлэгийн арга хэмжээг зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн аймгийн удирдлага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, хамт олонд гүн талархал илэрхийлэе

"Тунгалаг мэлмий" сайн дурын хүмүүнлэгийн ажиллагаа ирэх жил дахин зохион байгуулагдах бөгөөд нүдний хараагаа оношлуулах хүсэлтэй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ажилтан албан хаагчид, ахмадууд харьяа байгууллагынхаа ахмадын хороонд бүртгүүлэн захиалга өгч хамрагдах боломжтой.

МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБОО



"ЦЭВЭР АГААР-ЦЭМЦГЭР ОРЧИН АЯЛАЛ"-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 353 дугаар анги цэргийн алба хаагчдын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан "Цэвэр агаар цэмцгэр орчин" сэдэвт Бид нэг хамт олон уриатайгаар нэг өдрийн аяллыг зохион байгууллаа.

Энэхүү аялал нь бие бүрэлдэхүүнийг эрүүл агаарт гаргах, ажлын эрч хүчийг сэргээх, сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэхэд чиглэгдсэн юм.

Аяллын хүрээнд цэргийн алба хаагчид заавал сурах 10 бүжгийг сурч, олс таталт болон хөгжөөнт буухиа тэмцээнүүдээр өрсөлдөж нэг өдрийг сэтгэл дүүрэн хамтдаа өнгөрүүлээ. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд бие бүрэлдэхүүн Налайх дүүргийн байгалийн үзэсгэлэнт газрын 5 км орчим талбайг цэвэрлэлээ.